



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 06 сарын 05 өдөр

Дугаар 226

Улаанбаатар хот

Зээлийн гэрээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15, 62.1.16 дахь заалт, 88 дугаар зүйлийн 88.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Агаарын бохирдлыг бууруулах зарим арга хэмжээний тухай” 88 дугаар тогтоол, “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 6.10.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний хүрээнд хийгдэх гэр хорооллын 20602 айл өрхийг цахилгаанаар халаах техникийн боломж бүрдүүлэх төслийн ажлыг санхүүжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр 35,455,000,000.00 (гучин таван тэрбум дөрвөн зуун тавин таван сая) хүртэл төгрөгийн зээлийн гэрээг холбогдох хууль тогтоомжийн дагуу зээл, зээлийн хүүгийн нөхцөлийг судлан арилжааны банктай байгуулах эрх олгохыг “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд зөвшөөрсүгэй.

2. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

0001903